



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/234

Номгон

Г Монгол бичгийн тэргүүний уншигч Г
шалгаруулах “Үндэсний бичиг, соёл”
аймгийн уралдаан зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол хэлний тухай хуулийн 17.1.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.“Монгол бичгийн тэргүүний уншигч” шалгаруулах “Үндэсний бичиг, соёл” аймгийн уралдааныг 2026 оны 04 сарын 23-нд зохион байгуулсугай.

2.Зохион байгуулахад шаардагдах 2,648,000 (Хоёр сая зургаан зуун дөчин найман мянга)-н төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

3.Үйл ажиллагааг удирдамжийн дагуу зохион байгуулж, тайланг 2026 оны 05 сарын 05-ны дотор Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлэхийг Боловсролын газар (Л.Аюурзана)-т, Нийтийн номын сан (Б.Түвшинчимэг)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (В.Наранчимэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

626010615

БАТЛАВ
ХЭЛНИЙ БОДЛОГЫН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН АЙМГИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА Э.ЭНХБАТ

.....оны.....дүгээр сарын.....

УДИРДАМЖ

2025 оны 04 дүгээр сарын 01

Номгон

Монгол бичгийн тэргүүний уншигч шалгаруулах
“Үндэсний бичиг, соёл” аймгийн уралдааны тухай

Нэг. ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 105 дугаар зарлиг, Монгол хэлний тухай хууль, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн III”, “Боловсролыг дэмжих жил”, аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлийн 2026 оны ажлын төлөвлөгөөний 2.1.6-д тусгагдсан ажил, арга хэмжээний дагуу боловсруулав.

Хоёр. ЗОРИЛГО:

Жил бүрийн 5 дугаар сарын эхний 7 хоногт тэмдэглэн өнгөрүүлдэг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын өдрийг угтаж эх хэл, бичиг үсгээ судлах, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурагчдад өв соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх зорилготой болно.

Гурав. ХАМРАХ ХҮРЭЭ:

- VI-VII-р ангийн сурагчид
- VIII-IX ангийн сурагчид
- X-XII ангийн сурагчид
- Насанд хүрэгчид /мэргэжлийн багш нар оролцохгүй/

Дөрөв. ХУГАЦАА:

2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 04 дүгээр сарын 23

Тав. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Сурагчдын насны ангилал:

2026 оны 04 дүгээр сарын 10-20 -ны өдрийг хүртэл 19 сум, аймгийн төвийн ЕБС-иуд үндэсний бичгийн “Тэргүүний уншигч сурагч”-аа тодруулж, шалгарсан сурагчдыг

04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймгийн Нийтийн номын сангийн 117 тоотод бүртгүүлнэ.

19 сумаас насны ангилалд тус бүр 1-2 сурагч, аймгийн төвийн сургууль насны ангилалд тус бүр 2-3 сурагчийг шалгаруулан аймгийн уралдаанд оролцуулна.

Насанд хүрэгчид:

2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймгийн Нийтийн номын санд бүртгүүлнэ.

Аймгийн уралдаан нь 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Аймгийн Нийтийн номын санд 10.00 цагт эхэлнэ.

VIII-IX, X-XII ангийн насны ангилалд шалгарсан 3 сурагч 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдах улсын XX уралдаанд оролцоно.

Зургаа. ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Монгол үндэсний хувцастай оролцоно.
- Шүүгчээс өгсөн эхийг түгдрэлгүй, үсэглэхгүй, алгасахгүй үнэн зөв, тод, нэгэн жигд хурдаар уншина.

Долоо. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Баянхонгор аймгийн ЗДТГ

Баянхонгор аймгийн Боловсролын газар

Баянхонгор аймгийн Нийтийн номын сан

Найм. ШАЛГАРУУЛАЛТ:

Уралдааныг мэргэжлийн багш нар шүүн явуулна. Насны ангилал тус бүрд эхний 3 байр, тусгай 1 байрыг шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

УТАС : 80116407

ХЯНАСАН:  Б.ТҮВШИНЧИМЭГ
ЗАХИРАЛ
УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН
НОМЫН САНЧ  Б.ЯНЖМАА